

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ТТЗ-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/020/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:  
[erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:  
[tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:  
[davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 01/312  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Х.ТАЙВАНБАЯР ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Мөрөн сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэн үндсэн хөрөнгөнд бүртгэж үндсэн хөрөнгийг 14,290.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого нэр төрлөөр нь авч үзвэл нийт 1,124.7 сая төгрөгөөр тасарсан, Хоршоо хөгжүүлэх сангийн 25.3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулаагүй, сумын үндсэн чиг үүрэгт хамааралгүй арга хэмжээнд 186.6 сая төгрөгийн төсөв баталж, хэрэгжүүлсэн зэрэг зөрчил илэрсэн.

## **Бусад асуудлын хэсэг**

Мөрөн сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2025 оны үр дүнгийн гэрээг 23 зорилт 205 арга хэмжээтэй байгуулж, 99.3 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

**АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/Мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		6,120,893.16	3,784,170.88
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	5,313,070.22	2,182,649.34
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	300,720.53	240,431.86
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	580	760
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	506,522.41	1,295,386.46
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	0.0	64,943.22
7	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		37,006,121.97	44,081,193.39
8	1.2.1 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	624,285.71	847,224.01
9	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	36,381,836.25	43,233,969.38
10	1.2.2.02 Биет хөрөнгө		25,650,233.34	31,322,325.71
11	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	10,731,602.92	11,911,643.68
12	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		43,127,015.12	47,865,364.26
13	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		223,833.2	1,282,352.49
14	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		223,833.2	1,282,352.49
15	2.1.1.03 Өглөг		223,833.2	1,282,352.49
16	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		42,903,181.92	46,583,011.77
17	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		42,903,181.92	46,583,011.77
18	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		14,032,796.79	14,032,796.79
19	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		28,253,592.67	31,933,703.7
20	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		616,792.46	616,511.28
21	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		43,127,015.12	47,865,364.26

**Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/Мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		31,551,482.32	37,977,846.63
2	ТАТВАРЫН ОРЛОГО		22,043,617.31	22,364,707.2
3	Орлогын албан татвар		19,393,433.02	19,766,130.12
4	Хувь хүний орлогын албан татвар		19,393,433.02	19,766,130.12
5	Хөрөнгийн албан татвар		818,089.29	902,420.85
6	Бусад татвар, төлбөр, хураамж		1,832,095	1,696,156.23
7	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	5,279,218.34	15,613,139.43
8	Хөрөнгийн орлого		3,900	0.0
9	Тусламжийн орлого		7,312.5	3,327,696.65
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,228,646.67	0.0

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	25,818,784.38	33,102,774.01
12	УРСГАЛ ЗАРДАЛ		25,818,784.38	32,862,360.95
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		15,735,414.9	18,013,659.7
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,767,533.07	2,264,702.93
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		218,406.09	278,057.99
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		4,304,014.32	5,017,958
17	Хангамж, бараа материалын зардал		1,088,496.69	402,289.72
18	Эд хогшил, урсгал засварын зардал		517,775.7	294,474.01
19	Томилолт, зочны зардал		30,915.24	30,876.74
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,252,262.79	1,538,726.96
21	Бараа үйлчилгээний бусад зардал		6,556,010.99	8,186,573.35
22	ТАТААС		3,128,000	4,410,800
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6,955,369.49	10,437,901.25
24	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	240,413.05
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		5,732,697.94	4,875,072.62
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		187,253.67	1,169,897.97
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-187,253.67	-1,169,897.97
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		5,545,444.27	3,705,174.65

Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	27,573,174.76	28,243,209.61
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	22,043,617.31	22,364,707.2
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	19,393,433.02	19,766,130.12
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	818,089.29	902,420.85
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	1,832,095	1,696,156.23
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,513,773.46	1,333,714.05
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	314,609.35	357,873.08
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,712.19	4,569.1
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,297,755.11	5,878,502.41
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	1,293,855.11	1,445,295.74
11	1.1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	3,900	0.0
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	3,524,987.03
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	908,219.63
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,231,802.34	0.0

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,855,056.35	27,984,262.79
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	21,855,056.35	27,984,262.79
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,793,633.13	13,158,549.54
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,768,022.55	2,259,013.34
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	218,406.09	278,057.99
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,304,014.32	4,246,448.63
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	81,897.46	74,970.43
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	0.0	1,270
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	522,477.55	277,992.26
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	31,405.24	23,976.74
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,241,530.47	1,718,971.88
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	3,625,879.45	4,277,848.27
27	1.1.1.2.01.3 ТАТААС	3,128,000	4,410,800
28	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,933,423.22	10,414,913.25
29	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,718,118.41	258,946.82
30	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	2,895,069.08	2,969,367.7
31	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,895,069.08	2,969,367.7
32	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	2,895,069.08	2,969,367.7
33	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,895,069.08	-2,969,367.7
34	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	140,000	420,000
35	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-140,000	-420,000
36	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,683,049.33	-3,130,420.88
37	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,630,020.88	5,313,070.22
38	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,313,070.22	2,182,649.34

Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,444,914.05		36,444,914.05
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	98,632.56		98,632.56
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	36,543,546.62		36,543,546.62
4	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	814,191.03		814,191.03
5	Тайлант үеийн үр дүн	5,545,444.27		5,545,444.27
6	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	42,903,181.92		42,903,181.92

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

7	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	42,903,181.92		42,903,181.92
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,801.3		-1,801.3
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	42,901,380.62		42,901,380.62
10	Тайлант үеийн үр дүн	3,681,631.15		3,681,631.15
11	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	46,583,011.77		46,583,011.77

Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	29,530,366.2	24,356,172.4	5,174,193.8	82.5
	ОНХС-ийн орлогын шилжүүлэг	781,363.9	908,219.6	-126,855.7	116.2
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,521,704.9	18,067,285.9	5,454,419.0	76.8
	Эргэж төлөгдөх зээл /СХСан/	170,640.0	282,008.7	-111,368.7	165.3
	Давсан орлого дансны үлдэгдлээс	5,056,657.4	5,098,658.1	-42,000.7	100.8
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,530,366.2	27,428,255.3	-2,102,110.9	92.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,556,271.7	24,109,392.3	-1,446,879.4	94.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,715,189.8	9,286,679.0	-428,510.8	95.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,322,352.6	2,259,013.3	-63,339.3	97.3
210101	Үндсэн цалин	1,326,966.4	1,103,419.5	-223,546.9	83.2
210102	Нэмэгдэл	805,208.2	984,784.0	179,575.8	122.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	148,928.0	129,559.8	-19,368.2	87.0
210104	Урамшуулал	41,250.0	41,250.0	0.0	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	289,044.1	278,058.0	-10,986.1	96.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,369,827.0	4,315,442.6	-54,384.4	98.8
210301	Гэрэл, цахилгаан	392,338.0	329,954.4	-62,383.6	84.1
210302	Түлш, халаалт	3,699,339.0	3,704,980.4	5,641.4	100.2
210303	Цэвэр, бохир ус	278,150.0	280,507.8	2,357.8	100.8
2104	Хангамж, бараа материалын зардал	72,445.7	53,847.8	-18,597.9	74.3
210401	Бичиг хэрэг	21,125.7	16,905.1	-4,220.6	80.0
210402	Тээвэр, шатахуун	22,672.6	15,409.9	-7,262.7	68.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,341.7	10,135.2	-1,206.5	89.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,305.7	11,397.6	-5,908.1	65.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,925.7	293,933.0	-6,992.7	97.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000.0	5,980.0	-20.0	99.7
210602	Тавилга	21,000.0	19,493.3	-1,506.7	92.8
210604	Урсгал засвар	273,925.7	268,459.7	-5,466.0	98.0
2107	Томилолт, зочны зардал	34,918.0	23,976.7	-10,941.3	68.7
210702	Дотоод албан томилолт	27,518.0	18,631.0	-8,887.0	67.7
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7,400.0	5,345.7	-2,054.3	72.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,928,394.6	1,640,348.0	-288,046.6	85.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,920,592.6	1,635,106.3	-285,486.3	85.1
210803	Даатгалын үйлчилгээ	1,282.0	1,282.0	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	378.0	73.0	-305.0	19.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	142.0	105.1	-36.9	74.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,000.0	3,781.7	-2,218.3	63.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	397,282.1	422,059.4	24,777.3	106.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	389,394.1	418,652.4	29,258.3	107.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,888.0	3,407.0	-4,481.0	43.2
212	ТАТААС	4,419,100.0	4,410,800.0	-8,300.0	99.8

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	4,419,100.0	4,410,800.0	-8,300.0	99.8
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	4,419,100.0	4,410,800.0	-8,300.0	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,421,981.9	10,411,913.3	-1,010,068.7	91.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	11,308,658.9	10,300,000.0	-1,008,658.9	91.1
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	11,308,658.9	10,300,000.0	-1,008,658.9	91.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	113,323.0	111,913.3	-1,409.8	98.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	54,735.7	54,735.7	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	58,587.3	57,177.6	-1,409.8	97.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,528,892.5	2,898,863.1	-630,029.4	82.1
223001	Бусад хөрөнгө	3,528,892.5	2,898,863.1	-630,029.4	82.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	445,202.0	420,000.0	-25,202.0	94.3
230001	Эргэж төлөгдөх зээл	445,202.0	420,000.0	-25,202.0	94.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	5,098,658.1	5,098,658.1	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	2,026,575.2	2,026,575.2	0.0

Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	190,825.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	190,825.2
122	Тусламжийн орлого	190,825.2
1221	Хандив тусламж /дотоод/	190,825.2
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	190,825.2
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	133,247.1
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	57,578.1
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	172,024.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	172,024.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	169,024.0
2104	Хангамж, бараа материалын зардал	21,122.6
210401	Бичиг хэрэг	4,532.4
210402	Тээвэр, шатахуун	16,170.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	420.0
2105	Нормативт зардал	1,270.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,270.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,632.5
210604	Урсгал засвар	14,632.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	108,123.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	108,123.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,875.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,875.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000.0
4	Төвлөрүүлэг үйлжүүлэг	18,801.2

## **АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сан, 5 ОНӨААТҮГ-ийн нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 10 байгууллага түүвэрт хамрагдсан бөгөөд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 1,694.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,695.6 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмжийг өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 120.2 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 1 алдаа, Худалдан авах ажиллагаатай холбоотой 126.9 сая төгрөгийн 1 зөрчил илэрсэн байна.

Аудитаар илэрсэн алдааг аудитын явцад залруулан бүртгэсэн бөгөөд 126.9 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг өгсөн байна.

Аудитаар илэрсэн материаллаг зөрчлийн дүн тогтоосон материаллаг түвшнээс хэтрээгүй тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

### **Төлбөрийн акт**

Мөрөн сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### **Албан шаардлага**

Мөрөн сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага өгөөгүй.

### **Зөвлөмж**

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл нийт 1,124.7 сая төгрөгийн орлогыг тасалсан байна. Үүнд:

- Мөрөн сумын төсөвт төвлөрүүлэх орлого: Хөрөнгийн орлогыг 404.1 сая төгрөгөөр, Хөрөнгө борлуулсны орлого 102.4 сая төгрөгөөр, Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 8.7 сая төгрөгөөр, Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 169.9 сая төгрөгөөр, Газрын төлбөрийн орлогыг 7.1 сая төгрөгөөр, торгуулийн орлогыг 116.7 сая төгрөгөөр нийт 808.9 сая төгрөгөөр тасалсан.
- Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого: ААНОАТ-ын 40 хувийн орлогыг 283.3 сая төгрөгөөр, Татварын бус хүү торгуулийн орлогыг 279.7 сая төгрөгөөр тасалсан.
- Улсын төсөвт төвлөрүүлэх орлого: Ус бохирдуулсны төлбөрийн орлогыг 2.1 сая төгрөгөөр, Агаарын бохирдол /авто/ орлогыг 34.0 сая төгрөгөөр нийт 36.1 сая төгрөгөөр тасалсан.

Орлогын төлөвлөгөөг тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах

#### **2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал.**

##### Илрүүлэлт:

Мөрөн сумын Засаг даргын 2025.11.24-ны өдрийн захирамжаар Бүтээлч Мөрөнчүүд үйл ажиллагааны хөтөлбөрт зориулан төсөв зарцуулах захирамжийг гаргасан бөгөөд Мөрөн сумын Засаг дарга нь Хөдөөгийн шийдэл ХХК-тай гэрээ байгуулан үндсэн үнийн 50 хувиар тооцож 186.6 сая төгрөгийн хүлэмжүүдийг худалдан авч иргэдэд олгосон нь Мөрөн сумын ЗДТГ-ын үндсэн чиг үүрэгт хамааралгүй төсвийн үр ашгийг бууруулсан зардал байна. Тухайлбал:

- Иргэдэд олгосон хөрөнгийг эргэн төлөх зээлийн гэрээг Хөдөөгийн шийдэл ХХК иргэдтэй байгуулсан.
- Тус арга хэмжээ нь Хөдөөгийн шийдэл ХХК-ийн үндсэн чиг үүргийн ажил байхад Мөрөн сумын ЗДТГ оролцон үр ашиггүй зардал гаргасан.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3.үр ашигтай байх; 15.1.3."хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"-гүй байх гэсэн заалтууд болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын чиг үүрэгт хамааралгүй төсөл арга хэмжээнд төсөв баталж хуваарилахгүй байх.

**3. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар**

Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн 1 иргэнтэй холбоотой 25.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

**4. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал.**

Аудитын илрүүлэлт:

Мөрөн сумын ОНХС-ийн хөрөнгөөр 299.0 сая төгрөгөөр 2 автобусыг худалдан авсан байна. Тус 2 автобус нь 2019 болон 2020 онд үйлдвэрлэгдэн солонгос улсад ашиглагдаж байгаад 2025 онд орж ирсэн бөгөөд төсөвт өртгийн хувьд зах зээлийн үнээс хэт өндөр үнээр худалдан авсан байна. /Тус асуудал нь хууль хяналтын байгууллагад хянагдаж байна./

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа зах зээлийн бодит үнэ ханшид нийцүүлэн төсөвт өртгийн дээд хязгаарыг тогтоож ажиллах.

**5. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал.**

Аудитын илрүүлэлт:

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын Брэндбүүк бүрдүүлэх зөвлөх үйлчилгээний зардалд 58.5 сая төгрөгийг зарцуулсан нь зах зээлийн үнээс өндөр байна. Тус брэнд бүүк нь байгууллагын визуал хэв загварыг тодорхойлсон боловч бодит хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай зарим чухал заавар, стандартууд хангалтгүй байна. Тухайлбал, брэндийн элементүүдийг байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, дотоод баримт бичиг, цахим орчин, хэвлэл мэдээлэл болон олон нийтийн харилцаанд хэрхэн жигд хэрэглэх талаар нарийвчилсан заавар, хяналтын механизм тусгагдаагүй. Мөн брэндийн ашиглалт, шинэчлэлт, хариуцсан нэгжийн үүрэг, хяналтын журам тодорхой бус байгаа нь

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

байгууллагын хэмжээнд нэг мөр, тогтвортой брэндийн хэрэглээг хангахад дутагдалтай байна.

Өгсөн зөвлөмж:

Үр ашиггүй төсөл арга хэмжээнд төсөв баталж хэрэгжүүлэхгүй байх.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөрөн сумын ТТЗ										
<b>Дүн</b>										
Харьяа байгууллагуудын алдаа										
НББ тайлагналын алдаа /ЗДТГ/	1	120.2	1	120.2			1	120.2		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>120.2</b>	<b>1</b>	<b>120.2</b>			<b>1</b>	<b>120.2</b>		
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>120.2</b>	<b>1</b>	<b>120.2</b>			<b>1</b>	<b>120.2</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/сая төгрөгөөр/ Үүнээс			
							Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын чиг үүрэгт хамааралгүй төсөл арга хэмжээнд төсөв баталж хэрэгжүүлсэн	1	186.6					1	186.6		
Үр ашиггүй төсөл арга хэмжээнд төсөв баталж хэрэгжүүлсэн	1	58.5					1	58.5		
Орлогыг нэр төрлөөр нь тасалсан	1	1,124.7					1	1,124.7		
ХХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага барагдуулаагүй	1	25.8					1	25.8		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>1,395.6</b>					<b>4</b>	<b>1,395.6</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/сая төгрөгөөр/ Үүнээс			
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авалт хийсэн	1	299.0					1	299.0		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>299.0</b>					<b>1</b>	<b>299.0</b>		
Харьяа байгууллагуудын зөрчил										
Худалдан авах ажиллагааны тухай хууль зөрчсөн	1	126.9					1	126.9		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>126.9</b>					<b>1</b>	<b>126.9</b>		
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>425.9</b>					<b>2</b>	<b>425.9</b>		